



ҮНДЭСНИЙ
ХУВЬЧЛАЛЫН
САН

2024

НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН

ээлжит хурлын материал

2024 он

ЭРХЭМ ХҮНДЭТ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ТАНАА

Монголын хамгийн анхны хамтын хөрөнгө оруулалтын сан болох Үндэсний Хувьчлалын Сан нь 2023 онд Монгол улс дахь төрийн өмчит компаниудын хувьчлалд оролцох замаар хөрөнгө оруулагчдадаа өндөр өгөөж өгөх эрхэм зорилгынхоо хүрээнд амжилттай ажиллаа.

2023 онд бид Монголын Хөрөнгийн Бирж ХК-ийн хувьчлалд стратегийн хөрөнгө оруулагчаар оролцож 80 гаруй хувийн өсөлт үзүүлээд байгаа билээ. Мөн бид зөвхөн Монголын бус гадаадын өндөр өгөөж ашиг өгөх боломжтой хувьцаанд хөрөнгө оруулалтууд хийн ажилладаг ба чип үйлдвэрлэлээрээ дэлхийд тэргүүлэгч Nvidia Corp [NASDAQ:NVDA] зэрэг хувьцаанаас 150 хувийн өсөлтийг гарган авч чадлаа.

Сангийн хөрөнгө оруулалтын багцын 80 орчим хувь нь Монголын томоохон, үйл ажиллагаа тогтворжсон найдвартай компанийн хувьцаануудаас бүрддэг. 2024 онд бидний хувьд дараагийн өндөр өсөлтийн жил байх болов уу хэмээн таамаглаж байна.

Сангийн менежер

Ч.Даваасамбуу

АГУУЛГА

- 1. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ГҮЙЦЭТГЭЛ**
- 2. НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ ЗАРЛАХ ТУХАЙ ШИЙДВЭР, ХУРЛЫН ДЭГ, ЗАР**
- 3. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ТАНИЛЦУУЛГА, ТАЙЛАН**
- 4. НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ХЭЛЭЛЦЭХ АСУДУЛЫН ДЭЛГЭРЭНГҮЙ**
- 5. ХАВСРАЛТ**

1. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ГҮЙЦЭТГЭЛ

ТАНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ГҮЙЦЭТГЭЛ

- Үндэсний Хувьчлалын Сан хамтын ХОС (MSE:ХОС) нь 2020 оны 10 дугаар сард үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш 3 жилийн хугацаа өнгөрчээ. Энэ хугацаанд сангийн цэвэр хөрөнгийн дүн ₮5 тэрбумаас ₮6.3 тэрбумд хүрч чамлахааргүй өсөлтийг үзүүлжээ. 2023 оны эцсийн байдлаар нэгж эрхэд ногдох цэвэр хөрөнгийн үнэлгээ ₮127.5 хүрч оны эхнээс 9.6% буурсан байна. Харин үүсгэн байгуулагдсан цагаас хойш цэвэр хөрөнгийн үнэлгээ 27.5%-иар өсөөд байна.
- ХОС нь 2021 онд багцынхаа дийлэнх хувийг урт хугацаанд өндөр өгөөж өгөх компаниудыг сонгон хөрөнгө оруулалтууд хийсэн. ХОС нь хамгийн сайн үзүүлэлттэй урт хугацаанд үнэ цэнээ хадгална гэж тооцоолсон компаниудаар өөрийн хувьцааны багцаа бүрдүүлсэн. Улмаар бид 2023 онд Монголын хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй ЛэндМН ББСБ ХК (MSE:LEND) болон Тавантолгой ХК (MSE:TTL) зэрэг хувьцааг Growth at a reasonable price (GARP) буюу өсөлттэй хувьцааг боломжийн үнээр худалдан авах хөрөнгө оруулалтын стратеги ашиглан бага ханшаар худалдан авсан. ХОС-ийн багц дахь эдгээр хувьцаа дээр өндөр өсөлттэй байж, нийт багцын өгөөжийг багагүй хэмжээгээр нэмэгдүүлж чадсан байна.

Хөрөнгө оруулалтын хэрэгслүүдийн өгөөжийн харьцуулалт

	2019	2020	2021	2022	2023
Үндэсний Хувьчлалын Сангийн өгөөж		25.6%	91.2%	-24.4%	-9.59%
ТОП-20-ийн өгөөж	-8.6%	-1.7%	130%	-15.4%	10.31%
Хадгаламжийн хүү	13.5%	11.3%	~9%	10.3%	12.00%

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж, Монголбанк

ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САНГИЙН ТОВЧ ГҮЙЦЭТГЭЛ

Тикэр
ХОС

Гаргасан нэгж эрх
50 сая ширхэг

Нэгж эрх эзэмшигчийн тоо
6,163

Нэгж эрхийн хаалтын ханш
₮106.42

Зах зээлийн үнэлгээ
₮5.32 тэрбум

Жилийн арилжааны эргэлт
₮385 сая

Нэгж эрхийн NAV
₮127.5

Нийт цэвэр хөрөнгө NAV
₮6.38 тэрбум

2. НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ ЗАРЛАХ ТУХАЙ ШИЙДВЭР, ХУРЛЫН ДЭГ, ЗАР

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Нэгж эрх эзэмшигчдийн хурал
зарлан хуралдуулах тухай

Монгол Улсын Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4 дэх хэсэг, 60 дугаар зүйлийн 60.1, 60.2 дахь хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны №275 тоот тогтоолоор батлагдсан "Хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түүнд хяналт тавих журам"-ын 9 дүгээр зүйлийн зохицуулалтыг тус тус үндэслэн "Үндэсний Хувьчлалын Сан" Хамтын ХОС-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс **ТОГТООХ** нь:

"Үндэсний Хувьчлалын Сан" ХОС-ийн Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурал (цаашид "Хурал" гэх)-ыг 2024 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 15:00 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 хороо, Сүхбаатарын талбай-2, Сентрал тауэр, 17 давхар, Криптос ресторан хаягт хуралдуулсугай.

- Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг Нэгдүгээр хавсралтаар, Нэгж эрх эзэмшигчдийн хурлын дэгийг Хоёрдугаар хавсралтаар, Хурлын нийтэд хүргэх зарын загварыг Гуравдугаар хавсралтаар, Саналын хуудасны агуулга, загварыг Дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.
- Хуралд оролцох эрхтэй Нэгж эрх эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2024 оны 4 дүгээр сарын 08-ны өдрөөр тогтоосугай.
- Хурлын мэдэгдлийг Санхүүгийн зохицуулах хороо болон Арилжаа эрхлэх байгууллагад 2024 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн дотор хүргүүлсүгэй.
- Хурал хуралдуулах тухай мэдээг Хөрөнгийн биржийн цахим хуудас, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, Ард Менежмент ҮЦК ХХК-ийн албан ёсны цахим хаяг <https://ardmanagement.mn/> дамжуулан 2024 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн дотор нийтэд зарласугай. Давтан зарыг 2024 оны 4 дугаар сарын 5-ны өдөр олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулсугай.
- Нэгж эрх эзэмшигчдийн танилцаж болох хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, гарах шийдвэрийн төсөл, саналын хуудас, танилцуулга зэрэг бусад холбоотой баримт бичгийг бэлэн болгож 2024 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн дотор үнэт цаасны компаниудад хүргүүлсүгэй
- Нэгж эрх эзэмшигчдийн хуралд оролцох боломжгүй нэгж эрх эзэмшигчдийн Санал авах хуудсаар урьдчилж санал өгөх сүүлчийн хугацааг 2024 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 16:00 цагаар тасалбар болгосугай.

7. Нэгж эрх эзэмшигчдийн ирц, санал хураалт, асуултыг Ард Applikeйшн болон цаасан хэлбэрээр хослуулан авсугай.
8. Хурлын даргаар “Үндэсний Хувьчлалын Сан” ХОС-ийн ТУЗ-ийн дарга Г.Цогбадрахыг томилсугай.
9. Дараах нэр бүхий хүмүүсийг хурал зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнээр томилсугай. Үүнд:
 - Хурал зохион байгуулах комиссын дарга:
“Ард Менежмент ҮЦК” ХХК-ийн Гүйцэтгэх захирал Ч.Хандаа;
 - Хурал зохион байгуулах комиссын гишүүд:
“Үндэсний Хувьчлалын Сан” ХОС-ийн менежер Ч.Даваасамбуу;
“Үндэсний хувьчлалын сан” Хамтын ХОС-ийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Х.Саран;
10. Дараах нэр бүхий хүмүүсийг хурлын **Тооллогын комиссын бүрэлдэхүүнээр** томилсугай. Үүнд:
 - Тооллогын комиссын дарга:
Ө. Бямбагэрэл
Хуулийн зөвлөх
Ард Секюритиз ҮЦК ХХК
 - Тооллогын комиссын гишүүд:
Т. Батбаяр
Дилер
Ард Секюритиз ҮЦК ХХК
У. Намуун
Хөрөнгө оруулалтын банкны хэлтсийн ахлах
Ард Секюритиз ҮЦК ХХК
11. Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хурлыг зарлан хуралдуулж, хурлын зар мэдээг хүргэж, энэхүү тогтоолыг бүрэн дүүрэн, түргэн шуурхай гүйцэтгэхэд шаардлагатай бүх арга хэмжээг авч ажиллахыг Хурал зохион байгуулах комисст даалгасугай.
12. Нэгж эрх эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэсэн шийдвэр болон бусад материалыг Компанийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан хугацаанд Монголын хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал Ч.Хандаад даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Г.ЦОГБАДРАХ

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2024 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн
№24/02 тоот тогтоолын Хавсралт 1

НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ

1. Ард Менежмент ҮЦК ХХК-ийн хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээний жилийн тайлан
2. Үндэсний Хувьчлалын Сан хамтын ХОС-ийн 2023 оны үйл ажиллагааны тайланд хийсэн ТУЗ-ийн дүгнэлтийг батлах;
3. Кастодиан банкны хөрөнгө хадгалах үйлчилгээний жилийн тайлан;
4. Үндэсний Хувьчлалын Сан хамтын ХОС-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийгдсэн аудитын дүгнэлт;
5. Үндэсний Хувьчлалын Сан хамтын ХОС-ийн хөрөнгө оруулалтын бодлогын бичиг баримтад өөрчлөлт оруулах;
6. Үндэсний Хувьчлалын Сан хамтын ХОС-ийн зарласан нэгж эрхийн тоог нэмэгдүүлж, нэмж нэгж эрх гаргах зөшөөрөл олгох, үүнтэй холбоотой үүсэх эрхийг ТУЗ-д олгох;
7. Үндэсний Хувьчлалын Сан хамтын ХОС-ийн дүрэмд өөрчлөлт оруулах;
8. Үндэсний Хувьчлалын Сан хамтын ХОС-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох;
9. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны зардлын төсөв батлах.

НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ

(Хурал 15:00 цагт эхэлж 17:00 цагт дуусах)

№	Дэд хэсэг	Хуваарь
1	Хурлын ирцийг бүртгэх /тооллогын комисс/;	14:50-15:15
2	Хурлын ирцийг мэдээлэх /тооллогын комисс/;	15:15-15:20
3	Хурлын дарга хурлыг нээж, хурлаар хэлэлцэх асуудлууд болон хурлын дэгийг танилцуулах;	15:20-15:30
4	<ol style="list-style-type: none"> 1. Ард Менежмент ҮЦК ХХК-ийн хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээний жилийн тайлан 2. Үндэсний Хувьчлалын Сан хамтын ХОС-ийн 2023 оны үйл ажиллагааны тайланд хийсэн ТУЗ-ийн дүгнэлтийг батлах 3. Кастодиан банкны хөрөнгө хадгалах үйлчилгээний жилийн тайлан 4. Үндэсний Хувьчлалын Сан хамтын ХОС-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийгдсэн аудитын дүгнэлт 5. Үндэсний Хувьчлалын Сан хамтын ХОС-ийн хөрөнгө оруулалтын бодлогын бичиг баримтад өөрчлөлт оруулах 6. Үндэсний Хувьчлалын Сан хамтын ХОС-ийн зарласан нэгж эрхийн тоог нэмэгдүүлж, нэмж нэгж эрх гаргах зөшөөрөл олгох, үүнтэй холбоотой үүсэх эрхийг ТУЗ-д олгох 7. Үндэсний Хувьчлалын Сан хамтын ХОС-ийн дүрэмд өөрчлөлт оруулах 8. Үндэсний Хувьчлалын Сан хамтын ХОС-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох 9. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны зардлын төсөв батлах 	15:30-16:20
5	Хэлэлцэх асуудал тус бүрээр санал хураалт	16:20-16:30
6	Тооллогын комиссын тогтоолыг танилцуулах;	16:30-16:45
7	Хурлаас гарах шийдвэр, тогтоолыг танилцуулах;	16:45-16:55
8	Хурлыг хаах	17:00

ХУРЛЫН ЗАР

“ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН” ХОС-ИЙН НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

“Үндэсний Хувьчлалын Сан” ХОС-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн тогтоолоор Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурал зарлаж байна.

ХУРАЛ ХУРАЛДУУЛАХ ГАЗАР: Улаанбаатао хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Сүхбаатарын талбай-2, Централ тауэр, 17 давхар, Криптос ресторан;

ХУГАЦАА: 2024 оны 4 дүгээр сарын 27-ний өдрийн 15:00 цагт

ОНООСОН НЭР: “ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН” ХОС

ХУРЛЫН ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

- Ард Менежмент ҮЦК ХХК-ийн хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээний жилийн тайлан
- Үндэсний Хувьчлалын Сан хамтын ХОС-ийн 2023 оны үйл ажиллагааны тайланд хийсэн ТУЗ-ийн дүгнэлтийг батлах
- Кастодиан банкны хөрөнгө хадгалах үйлчилгээний жилийн тайлан
- Үндэсний Хувьчлалын Сан хамтын ХОС-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийгдсэн аудитын дүгнэлт
- Үндэсний Хувьчлалын Сан хамтын ХОС-ийн хөрөнгө оруулалтын бодлогын бичиг баримтад өөрчлөлт оруулах
- Үндэсний Хувьчлалын Сан хамтын ХОС-ийн зарласан нэгж эрхийн тоог нэмэгдүүлж, нэмж нэгж эрх гаргах зөшөөрөл олгох, үүнтэй холбоотой үүсэх эрхийг ТУЗ-д олгох
- Үндэсний Хувьчлалын Сан хамтын ХОС-ийн дүрэмд өөрчлөлт оруулах
- Үндэсний Хувьчлалын Сан хамтын ХОС-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох
- Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны зардлын төсөв батлах

БҮРТГЭЛИЙН ӨДӨР: 2024 оны 4 дүгээр сарын 8-ны өдөр

НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН ТАНИЛЦАЖ БОЛОХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ:

- Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалд санал өгөх саналын хуудас;
- Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлын дэг;
- Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлын тогтоолын төсөл;

Бүртгэлийн өдрөөр тасалбар болгосон нэгж эрх эзэмшигчдийн нэрсийн жагсаалтад орсон нэгж эрх эзэмшигч нь Ээлжит хуралд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан оролцох эрхтэй ба та ажлын өдрүүдэд 9:00–18:00 цагийн хооронд Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Чингисийн талбай-2, Централ Таур, 17 давхарт байрлах “Ард Секюритиз ҮЦК” ХХК-аар дамжуулан хэлэлцэх асуудалд саналын хуудсаар урьдчилан санал өгөх боломжтой.

Саналын хуудсыг урьдчилан хүлээн авах сүүлийн хугацаа 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 16:00 цаг байна.

Хурлын өдөр нэгж эрх эзэмшигчид Ард Applikeйшн болон саналын хуудсаар санал өгөх боломжтой.

Доорх газруудад хандаж Ээлжит хурлын материал, саналын хуудастай танилцана уу.

№	Байгууллагын нэр	Утас	Шуудангийн хаяг
1	Ард Секюритиз ҮЦК ХХК	(976) 7707 8181	info@ardsecurities.com
2	Ард Менежмент ҮЦК ХХК	(976) 7707 8282	info@ardmanagement.mn
3	Ард Менежмент ҮЦК ХХК	(976) 8906 9911	saran.h@ardmanagement.mn

3. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ТАНИЛЦУУЛГА, ТАЙЛАН

САНГИЙН ТАНИЛЦУУЛГА

“Үндэсний Хувьчлалын Сан” Хамтын ХОС нь Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан хуулийн этгээдийн эрхтэй, тусгай зориулалтын компани юм.

Нэр	“Үндэсний Хувьчлалын Сан” хамтын хөрөнгө оруулалтын сан эсхүл “Үндэсний Хувьчлалын Сан” Хамтын ХОС
Сангийн хэлбэр	Хаалттай хамтын хөрөнгө оруулалтын сан
Бүртгэл	- УБД: 9011801136 - РД: 645783
Үйл ажиллагаа	Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх
Хугацаа	Үүсгэн байгуулагдсан хугацаа: 2019-08-07 Үйл ажиллагаа явуулах хугацаа: 10 жил
Удирдлага	- Нэгж эрх эзэмшигчдийн хурал - Төлөөлөн удирдах зөвлөл - Гүйцэтгэх удирдлага: “Ард Менежмент ҮЦК” ХХК
Хөрөнгө итгэмжлэн удирдах компани	“Ард Менежмент ҮЦК” ХХК
Хөрөнгө хадгалах компани	“Голомт Банк” ХХК-ийн кастодиан банкны хэлтэс
Хаяг	- Монгол улс, СБД, Амарын гудамж, Ард Санхүүгийн Нэгдлийн байр, 2 давхар - Утас: 976-11-70078080 - И-мэйл: info@ardmanagement.mn - Вэб сайт: ardmanagement.mn

“Үндэсний Хувьчлалын Сан” Хамтын ХОС нь санхүүгийн мэдлэг, туршлага, судалгаанд үндэслэн хөрөнгө оруулагчдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийг өндөр өгөөж бүхий хөрөнгө оруулалтын хэрэгслүүдэд байршуулан хөрөнгө оруулагч нартаа өгөөж хүртээх зорилготой. Урт хугацаандаа Монгол Улсын томоохон төрийн болон орон нутгийн өмчит компани, объектуудын хувьчлалд оролцох, түүнээс өгөөж хүртэх зорилготой бол дунд хугацаандаа Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй нээлттэй хувьцаат компанийн хувьцаа болон бондод хөрөнгө оруулалт хийхээр зорьж байна. Ингэснээр хөрөнгө оруулагчид нэгдэн нийлж, Монгол Улсын эдийн засагт томоохон байр суурь эзэлдэг компаниудад хөрөнгө оруулах боломж бүрдэхээс гадна тэдгээрийн бүтээж буй баялгаас хувь хүртэх боломжтой болох юм.

“Үндэсний Хувьчлалын Сан” Хамтын ХОС нь Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй бөгөөд хөрөнгө оруулагчид сангийн нэгж эрхийг үнэт цаасны компаниараа дамжуулан худалдах, худалдан авах боломжтой.

ТУЗ ГИШҮҮДИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА



Галбадрахын Цогбадрах

ТУЗ-ийн дарга

Мэргэжил: Эдийн засагч,
санхүүч

Албан тушаал: “Ард
Даатгал” ХК-ийн ТУЗ-ийн
гишүүн, Гүйцэтгэх захирал,
“Ард Менежмент ҮЦК” ХХК-
ийн ТУЗ-ийн гишүүн



Батбилэгийн Золбоо

ТУЗ-ийн ердийн гишүүн

Мэргэжил: Санхүү, эдийн
засаг

Албан тушаал: “Ард
Санхүүгийн Нэгдэл” ХК-
ийн Гүйцэтгэх захирал,
“Ард Менежмент ҮЦК”
ХХК-ийн ТУЗ-ийн дарга



**Чулуунбаатарын
Хандаа**

ТУЗ-ийн ердийн
гишүүн

Мэргэжил: Эдийн
засагч

Албан тушаал: “Ард
Менежмент ҮЦК” ХХК-
ийн Гүйцэтгэх захирал



Пүрэвийн Баянсан

ТУЗ-ийн хараат бус гишүүн

Мэргэжил: Бизнесийн
удирдлага

Албан тушаал: ХҮИС-ийн
НББ, Санхүүгийн тэнхим
ахлах багш



Баяраагийн Баасандорж

ТУЗ-ийн хараат бус гишүүн

Мэргэжил: Эрх зүйч

Албан тушаал: “Батбаяр Энд
Партнэрс” ХХН-д өмгөөлөгч,
МУИС, Санхүү, татварын эрх
зүйн багш

УДИРДЛАГЫН БАГ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“Ард Менежмент ҮЦК” ХХК-ийн баг “Үндэсний Хувьчлалын Сан” хамтын ХОС-ийн өдөр тутмын үйл ажиллагааг эрхлэх, хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах зэрэг гүйцэтгэх удирдлагын бүрэн эрхийг хэрэгжүүлж ажилладаг.



САНГИЙН МЕНЕЖЕР



Чадраабал Даваасамбуу

Сангийн менежер

Мэргэжил: Санхүү, Хөрөнгө оруулалт

Албан тушаал: “Ард Менежмент ҮЦК” ХХК-ийн сангийн менежер

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОДЛОГО

ХОС нь хөрөнгө оруулалтын бодлогын хүрээнд тооцоо судалгаа хийсний үндсэн дээр хөрөнгө оруулалт хийдэг. Санхүүгийн Зохицуулах Хорооноос шинэчлэн баталсан журмын дагуу ХОС-ийн нийт хөрөнгийн 80-аас багагүй хувийг дотоод болон гадаадын хөрөнгийн зах зээлд бүртгэлтэй хувьцаат компанийн хувьцаанд хөрөнгө оруулалт хийж ажиллаж байна. Ингэхдээ бид компанийн суурь шинжилгээ, зах зээлийн судалгаа зэргийг багтаасан мэргэжлийн судалгаа шинжилгээнд үндэслэн хөрөнгө оруулалт хийж ажилладаг.

НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ


2023 оны эхэнд Үндэсний Хувьчлалын Сангийн нэгж эрх эзэмшигчдийн тоо 6,127 байсан бол оны эцсийн байдлаар 6,163-д хүрч 3%-иар өссөн үзүүлэлттэй байна.

Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах өдрийн байдлаар ХОС-ийн Нэгж эрх эзэмшигчдийн бүтэц дараах байдалтай байна:

Нэгж эрх эзэмшигч	Нэгж эрхийн тоо	Хувь
АРД ДААТГАЛ ХК	5,658,294	11.3%
ТУЛГА	3,000,000	6.0%
АРД МЕНЕЖМЕНТ ҮЦК	2,500,000	5.0%
М СИ ЭС ИНВЕСТМЕНТ	2,500,000	5.0%
АРД КРЕДИТ ББСБ	1,558,998	3.1%
БОГД БАНК	1,371,500	2.7%
АРДЫН ТЭТГЭВРИЙН ДАНС	1,150,697	2.3%
МАНДАХБАЯР	1,000,000	2.0%
НАРАНБАТ	1,000,000	2.0%
ЦЭРЭНДОЛГОР	807,141	1.6%
Бусад 6,153	29,453,370	58.9%
Нийт	50,000,000	100.00%

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГҮЙЦЭТГЭЛ

ХОС нь 2023 онд Монголын Хөрөнгийн Бирж дээр бүртгэлтэй хувьцаанд түлхүү хөрөнгө оруулалт хийж ажиллаа. Цэвэр хөрөнгийн үнэлгээ 2023 оны эцэст 6.38 тэрбум төгрөгт хүрч 9.8%-иар, зах зээлийн үнэлгээ нь 5.32 тэрбум төгрөгт хүрч 5.5%-иар тус тус буурсан. Харин үүсгэн байгуулагдсан цагаас хойш цэвэр хөрөнгийн үнэлгээ 27.5%-иар өссөн үзүүлэлттэй байна.




Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

	Зах зээлийн ханш	NAV(Цэвэр хөрөнгийн үнэ)
2023/12/31	106.42	127.5
Оны эхнээс %	-5.47%	-9.60%
Үйл ажиллагаа эхэлснээс хойш	6.42%	27.5%
2023 оны доод дээд	93.0-116.12	110.01-141.0

Тайлант хугацааны туршид сангийн хөрөнгийн бүтцийн өөрчлөлт (сая төгрөг)


Багцын өөрчлөлт



Эх сурвалж: Ард менежмент ҮЦК ХХК

Тайлант хугацааны эцэс дэх сангийн хөрөнгийн задаргаа (Зах зээлийн үнэлгээгээр болон өртгийн аргаар)

Зах зээлийн үнэлгээгээр




Эх сурвалж: Ард менежмент ҮЦК ХХК

ХОС-ийн хувьд хөрөнгө оруулалтын бодлого болон зохицуулагч байгууллагын тогтоосон харьцаа үзүүлэлтийг өртгийн аргаар тооцсон хувь хэмжээгээр тооцдог бөгөөд харьцаа үзүүлэлтийн шаардлагыг бүрэн хангаж байгаа болно. Багцын дахин тэнцвэржүүлэлтийг богино хугацааны давтамжтай хийх нь урт хугацааны хөрөнгө оруулалтын стратегитай харшилддаг тул бид өртгийн аргаар тооцож харьцаа үзүүлэлтийг хангаж ажилладаг билээ. Шалтгаан нь бид багцад байгаа өсөлттэй хувьцааны хувийн жинг бууруулахгүй байх, уналттай хувьцааны хувийн жинг өсгөхгүй байх нь хөрөнгө оруулалтын зөв бодлого гэж үздэгт оршино.

ХОС нь Монголын Хөрөнгийн Бирж дээрх нээлттэй компанийн хувьцаанд түлхүү хөрөнгө оруулалт хийдэг ба багцын дийлэнх буюу 80 хувийг дангаар бүрдүүлж байна. Тайлант хугацаанд гадаад дотоодын нөхцөл байдлаас шалтгаалан дотоод болон гадаадын тодорхой хувьцаануудаа зарж гарсан ба өсөлт үзүүлэх боломжтой хувьцаануудаар багцаа сэлгэн хөрөнгө оруулалтууд хийсэн. Мөн тогтмол өгөөжтэй хөрөнгө оруулалтын хэрэгсэл багцдаа нэмж багцын 10 орчим хувьд хүргэсэн.

2023 оны 12 сарын 31-ний байдлаар ХОС-ийн хувьцааны багцад нийт 30 хувьцаа байгаа бөгөөд үүнээс 25 нь дотоодын хувьцаа, 5 нь гадаад хувьцаа байна. Салбараар нь харвал санхүүгийн 10, өргөн хэрэглээний 4, түүхий эдийн 3, аж үйлдвэрийн 2, тогтмол бус хэрэглээний 3, технологийн 3, харилцаа холбооны салбарын 1 хувьцаануудаас багц бүрджээ.

Хувьцааны багц эдийн засгийн салбараар (Зах зээлийн үнэлгээгээр болон өртгийн аргаар, нийт хөрөнгийн багцад эзлэх хэмжээ %)




Эх сурвалж: Ард менежмент ҮЦК ХХК

САНГИЙН ЗАРДАЛ

Тайланд хугацаанд сангийн нийт хөрөнгийн өдрийн дундаж үлдэгдэл нь 6,052.1 сая төгрөг байсан бөгөөд зардлын нийт дүн нь 237.4 сая төгрөг болсон байна. Нийт хөрөнгийн дундаж үлдэгдлээс тооцсон нийт зардлын харьцаа нь 2023 онд 3.9% байна.

Зардлын задаргаа (Сая төгрөгөөр)




Эх сурвалж: Ард менежмент ҮЦК ХХК

САНГИЙН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

Тайлант хугацааны эцэст зах зээлийн үнэлгээгээр тооцвол багцын 84%-ийг эрсдэл өндөртэй хөрөнгө буюу хувьцаа эзэлж байгаа бол үлдсэн хэмжээг эрсдэл бага, тогтмол өгөөж бүхий хөрөнгүүд эзэлж байна.

Сангийн өдөр бүрийн цэвэр хөрөнгийн үнэлгээний (NAV) тоо мэдээнд тулгуурлан шинжилж үзвэл, эрсдэлийн үзүүлэлтүүд нь дараах байдалтай байна.

Өдрийн NAV хөдөлгөөний тархалт



Эх сурвалж: Ард менежмент ҮЦК ХХК

Нийт ажиглалтын тоо 246 бөгөөд өдрийн стандарт хазайлт нь 1.01% буюу жилийн 16.32% болно. Эрсдэлгүй хүүг Монголбанкны бодлогын хүү болох 13%-р тооцвол, Sharpe ratio (эрсдэлээр жигнэсэн өгөөжийг илтгэдэг харьцаа) нь 1.32 гарч байна.

НОГДОЛ АШГИЙН ТУХАЙ

ХОС-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 24/01 тоот тогтоолоор “Үндэсний Хувьчлалын Сан” ХОС нь 2023 оны үр дүнгээс шалтгаалан нэгж эрх эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэр гаргасан. ТУЗ нь зах зээлийн нөхцөл байдлыг харгалзан үзэж ирээдүйн учирч болох эрсдэл, эдийн засгийн нөхцөл байдалд тулгуурлан ногдол ашиг хуваарилахгүй байх шийдвэрт хүрсэн.

САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ

Нийт хөрөнгийн хувьд 6,402 сая төгрөгийн хөрөнгөтэй, цэвэр хөрөнгө 6,375 сая төгрөгт хүрсэн бөгөөд 2022 оны мөн үетэй харьцуулахад хөрөнгө 12.5%, цэвэр хөрөнгийн дүн 9.6%-ийн бууралтыг тус тус үзүүлсэн байна.

САНХҮҮГИЙН ТАЙЛАН(Аудитлагдсан)

Сая төгрөг

Үзүүлэлт	2022 Q4	2023 Q4
Нийт хөрөнгө	7,318	6,402
Мөнгө	276	550
Санхүүгийн хөрөнгө /Бодит/	6,651	5,657
Санхүүгийн хөрөнгө /Хорогдуулсан.Ө/	372	175
Авлага	19	7
Хойшлогдсон татварын хөрөнгө	-	13
Нийт өр төлбөр	267	26
Дансны өглөг	45	14
Орлогын татварын өр	7	12
Хойшлогдсон татварын өр	215	
Эздийн өмчийн дүн	7,051	6,375
Өмч	5,000	5,000
Хуримтлагдсан ашиг	2,051	1,375

ОРЛОГЫН ТАЙЛАН(Аудитлагдсан)

Сая төгрөг

Үзүүлэлт	2022 Q4	2023 Q4
Хүүгийн орлого	121	127
Ногдол ашгийн орлого	106	66
<u>Бодит үнэ цэнийн өсөлтийн олз</u>	(2,640)	(800)
<u>Гадаад валютын ханшийн зөрүүгийн цэвэр олз</u>	200	(2)
Бусад		76
Нийт ашиг (алдагдал)	(2,213)	(533)
<u>ХОМК-ийн үйлчилгээний зардал</u>	(177)	(155)
<u>Кастодианы үйлчилгээний зардал</u>	(25)	(22)
Бусад зардал	(127)	(61)
Нийт үйл ажиллагааны зардал	(329)	(237)
Татварын өмнөх ашиг	(2,543)	(771)
Хойшлогдсон татварын зардал	268	(22)
Тайлант үеийн цэвэр ашиг	(2,275)	(793)

4. 2024 НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН ДЭЛГЭРЭНГҮЙ

ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН ДЭЛГЭРЭНГҮЙ

1. Ард Менежмент ҮЦК ХХК-ийн хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээний жилийн тайлан

Ард Менежмент ҮЦК ХХК (цаашид “Ард Менежмент” гэх) нь өндөр өгөөжтэй, ирээдүйд хурдтай өсөх төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх зорилготой хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, удирдах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.

Ард Менежмент нь 2011 онд үүсгэн байгуулагдаж, 2016 онд Санхүүгийн Зохицуулах Хорооноос тусгай зөвшөөрөл авснаар хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх болсон.

Ард Менежмент нь 2020 оны 6 дугаар сарын 2-ны өдөр ХОС-той байгуулсан №20/14 тоот Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний дагуу Сангийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан явуулж байна.

2023 онд Ард Менежментээс ХОС-д гэрээний дагуу үзүүлсэн ажил үйлчилгээг тоймлон харуулвал:

Хөрөнгө итгэмжлэн удирдах

- ХОС-ийн хувьд 2023 оны 12-р сарын 31-ний байдлаар 6.38 тэрбум төгрөгийн цэвэр хөрөнгийн үнэлгээтэйгээр (*NAV нь нийт хөрөнгөөс нийт өр төлбөрийг хассан дүн*) хаагдсан ба энэ нь оны эхнээс 9.6 хувийн уналттай байсан бол үүсгэн байгуулагдсан цагаас хойш 27.5 хувийн өсөлтийг үзүүлсэн байна.
- Хөрөнгө оруулалтын багцыг удирдах. ХОС-ийн хувьд 2023 оны 12-р сарын 31-ний байдлаар 127 сая төгрөгийн хүүгийн орлого, 66 сая төгрөгийн ногдол ашгийн орлого тус тус олсон.
- Хөрөнгө оруулалтын судалгаа, шинжилгээг тогтмол хийж, хөрөнгө оруулалтын боломжийг эрэлхийлэх.
- Хөрөнгө оруулалтын нарийвчилсан төлөвлөгөөг батлуулж, сангийн менежерийн эрхийн хүрээнд хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах, зөвшөөрөгдсөн хэмжээнээс өндөр дүнтэй хэлцлүүдийг ТУЗ-н шийдвэрээр гүйцэтгэж байна.

ХОС-ийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах

- ХОС-ийн хөрөнгийн бүртгэлийг хөтлөх, хадгалах, хуульд заасан хугацаанд холбогдох төрийн байгууллагуудад санхүүгийн тайланг гаргаж хүргүүлэв.
- ХОС-ийн тайлан мэдээнүүдийг гаргаж, тайлагнахтай холбоотой Голомт Банкны кастодиан банкны газар, МХБ, СЗХ-той хамтран ажиллаж, МХБ болон Ард Менежментийн цахим сайтуудад Сангийн нэгж эрхийн арилжаа, хөрөнгө оруулалтын талаар тогтмол мэдээг хүргэв.
- ХОС-ийн багц дахь хөрөнгө оруулалтын хэрэгслүүдийн арилжааны захиалга хийх, төлбөр тооцоо төлөх, кастодиантай мэдээлэл солилцох ажлыг тогтмол гүйцэтгэж байна.
- Сангийн үйл ажиллагааг зохицуулахад шаардлагатай журам, заавар гаргаж, түүнийг боловсронгуй болгох, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.

ТУЗ, НЭЭ-ийн хурлыг зарлан хуралдуулах

Ард Менежмент нь тайлант хугацаанд ХОС-ийн ТУЗ-ийн 3 ээлжит хурал, 4 эчнээ санал хураалтыг зохион байгуулав. Мөн 2023 оны Сангийн нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлыг 2023 оны 04 сарын 29-ний өдөр амжилттай зохион байгуулж нийт нэгж эрх эзэмшигчдэдээ өмнөх оны тайлангаа танилцуулсан билээ.

Нэгж эрх эзэмшигчдийн хурлыг зохион байгуулах, түүнтэй холбоотой мэдээлэл тайлан бэлтгэх

Сангийн удаах нэгж эрх эзэмшигчдийн хурлыг ТУЗ-ийн 2024 оны 3 дугаар сарын 15-ны өдөр гаргасан тогтоолын дагуу Ард Менежмент ҮЦК ХХК зохион байгуулахаар хурлын бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

2. Үндэсний Хувьчлалын Сан Хамтын ХОС-ийн 2023 оны үйл ажиллагааны жилийн тайланд хийсэн ТУЗ-ийн дүгнэлтийг батлах

Үндэсний Хувьчлалын Сангийн төлөөлөн удирдах зөвлөл 2023 онд 3 удаа хуралдаж, 4 удаа эчнээ санал хураалтаар ээлжит бусаар хуралдсан байна.

Эдгээр хурлаар:

- 2023 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаар хэлэлцэх,
- Хөрөнгө Оруулалтын бодлого, цаашдын төлөвлөгөөг хэлэлцэх,
- Нэгж эрх эзэмшигчдийн хурал болон түүгээр хэлэлцэх асуудал батлах,
- Сонирхлын зөрчилтэй хэлцэл буюу Крипто Үндэстэн ХК, Ард Кредит ББСБ ХК-ийн хувьцааг багцад байршуулах зөвшөөрөл олгох,
- Ногдол ашиг хуваарилах эсэх тухай шийдвэр гаргах зэрэг Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Компанийн тухай хууль, ХОС-ийн дүрмийн хүрээнд доорх дүгнэлтийг гаргасан болно. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын бодлогын бичиг баримтын дагуу ХОС нь хөрөнгө оруулалтыг заасан хугацаанд хийж 2023 оны эцсийн байдлаар нэгж эрхэд ногдох цэвэр хөрөнгийн үнэлгээ 127.5 хүрч оны эхнээс -9.6%, зах зээлийн үнэ 106.42 хүрч оны эхнээс -8.4%-иар тус тус агшаад байна. Харин үүсгэн байгуулагдсан цагаас хойш цэвэр хөрөнгийн үнэлгээ 27.5%-иар өсөөд байна.

Гүйцэтгэх удирдлага нь Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Компанийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын бодлогын бичиг баримт болон бусад дотоод хууль журмын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж нэгж эрх эзэмшигчдийн эрх ашгийг дээдэлж тухай бүр дор дурдсан мэдээллүүд, тайлангуудыг хүргэж ажилласан байна.

Үүнд:

- Сангийн үнэ ханшийн мэдээллийг өдөр бүр олон нийтэд хүргэх.
- Улирал бүр ТУЗ-ийн хурлыг хуралдуулж сангийн үйл ажиллагаа, үр дүнг танилцуулах, шаардлагатай шийдвэрүүдийг гаргуулах.
- Улирал бүр Earning Call хийж сангийн үйл ажиллагааны талаар дэлгэрэнгүй мэдээллийг олон нийтэд хүргэх.
- Зохицуулагч байгууллагуудтай харилцах.
- Кастодиан банканд сангийн хөрөнгийг хадгалуулах, тайлан мэдээний үнэн зөв байдалд хяналт тавих.
- Сангийн хагас жилийн болон бүтэн жилийн тайланг бэлтгэж олон нийт болон зохицуулах байгууллагад хүргүүлэх.
- СЗХ-ны хяналт шалгалт болон хөндлөнгийн аудит хийлгэх, холбогдох материалыг бүрдүүлэх, үүрэг даалгаврыг биелүүлэх

Иймд гүйцэтгэх удирдлагын багийг Монгол улсын хамгийн анхны ХОС-ийн үйл ажиллагааг хууль журмын дагуу удирдаж ажилласан гэж Төлөөлөн удирдах зөвлөлөөс дүгнэж байна. Мөн цаашид хөрөнгө оруулалтын бодлогод тусгасан төлөвлөсөн өгөөждөө хүрч ажиллахыг Сангийн менежер болон гүйцэтгэх удирдлагад үүрэг болгож байна.

3. Кастодиан банкны хөрөнгө хадгалах үйлчилгээний жилийн тайлан;

Голомт банкны кастодиан банкны хэлтэсийн танилцуулга

Голомт Банк нь 2014 онд хамгийн анхны кастодиан банкны тусгай зөвшөөрлийг Санхүүгийн Зохицуулах Хорооноос авсан. Мөн 2017 онд үнэт цаасны тухайлсан бүртгэлийн үйл ажиллагааг хавсран эрхлэх нэмэлт тусгай зөвшөөрлийг авснаар хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгийг бүртгэж хадгалах, төлбөр тооцоог гүйцэтгэх, компанийн үйл ажиллагаанд төлөөлөхөөс гадна нэгж эрхийн тухайлсан бүртгэл хөтлөх, хөрөнгийн цэвэр үнэлгээ тооцоолох зэрэг цогц үйлчилгээг хөрөнгө оруулалтын менежментийн компаниас хараат бусаар гүйцэтгэж, хөрөнгө оруулагчид болон зохицуулагч байгууллагад сангийн талаар бие даасан мэдээлэл хүргүүлэх боломжтой болсон.

2020 онд Голомт банк болон Ард менежмент нь “Хөрөнгө хадгалах, кастодианы үйлчилгээний гэрээ” байгуулснаар Голомт банк нь “Үндэсний Хувьчлалын Сан” хамтын ХОС–д оруулсан хөрөнгө оруулалтыг нь бүртгэж хадгалах, үнэт цаас худалдаж авахтай холбоотой төлбөр тооцоог гүйцэтгэх, хүүгийн болон ногдол ашиг цуглуулах, нэгж эрхийн тухайлсан бүртгэл хөтлөх, хөрөнгийн цэвэр үнэлгээ тооцоолох зэрэг цогц үйлчилгээг үзүүлэх болсон.

Үйл ажиллагааны тайлан

Голомт Банкны кастодиан банкны хэлтэс нь ХОС-той байгуулсан “Хөрөнгө хадгалах, кастодианы үйлчилгээний гэрээ”-ний үндсэн дээр доорх үйлчилгээг үзүүлж байна. Үүнд:

- **Хөрөнгө хадгалах:** Үндэсний Хувьчлалын Сан хамтын ХОС-ийн нэр дээр кастодианы тусгайлсан данс нээж бүх төрлийн хөрөнгө оруулалт, үнэт цаасыг бүртгэн хадгалж, ангилал төрлийг тодорхой зааж, хадгалалтын нууцлал, бүрэн бүтэн байдлыг ханган ажиллаж байна. 2023 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Голомт банк нь Сангийн 6.37 тэрбум төгрөгийг хадгалж байна.
- **Нэгж эрхийн тухайлсан бүртгэл:** Голомт Банк нь ҮЦТХТ-тэй байгуулсан гэрээний үндсэн дээр нэгж эрхийн шинэ өмчлөгчдийн мэдээллийг өдөр тутам системээр холбогдон авч, тухайлсан бүртгэлийг өдөрт нь гүйцэтгэдэг. Голомт банк нь нийт 50.0 сая нэгж эрхийг бүртгэж баталгаажуулсан байна.
- **Хөрөнгийн цэвэр үнэлгээ:** Сар бүр, нийт 250 удаагийн тооцоолол хийж тулган баталгаажуулсан.
- **Тайлан мэдээ:** Хөрөнгийн үлдэгдлийн тайлан, NAV тайлан, дансны гүйлгээний дэлгэрэнгүй тайлан, шимтгэлийн тайлн.

4. Үндэсний Хувьчлалын Сан Хамтын ХОС-ийн 2023 оны санхүүгийн тайлан, түүнд хийсэн хараат бус аудитын дүгнэлт



ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

“Үндэсний хувьчлалын сан хамтын хөрөнгө оруулалтын сан” ХХК-ийн нэгж эрх эзэмшигчдэд

Аудиторын дүгнэлт

Бид “Үндэсний хувьчлалын сан хамтын хөрөнгө оруулалтын сан” ХХК (цаашид “Компани” гэх)–ийн 2023 оны 12 дугаар сарын 31–ний өдрөөрх Компанийн санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон үеийн жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр дээр нэрлэсэн санхүүгийн тайлангууд нь 2023 оны 12 дугаар сарын 31–ний өдрийн байдлаарх Компанийн санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон үеийн санхүүгийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд (“СТОУС”)–ын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт (“АОУС”)–уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагуудыг энэхүү тайлангийн “Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага” хэсэгт харуулав. Бид Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан “Мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм”–ийн дагуу Компаниас хараат бус бөгөөд уг дүрэмд заасны дагуу өөрсдийн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэд хангалттай, зохистой үндэслэл болж чадна гэдэгт бид итгэлтэй байна.

Санхүүгийн тайлантай холбоотойгоор удирдлагын хүлээх хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг СТОУС–ын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах ба залилан, алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжийг бий болгоход шаардлагатай гэж удирдлагын тодорхойлсон дотоод хяналтуудад удирдлага хариуцлага хүлээнэ.

Компанийн удирдлага нь санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ Компанийн үйл ажиллагааг зогсоох эсвэл татан буулгахаар төлөвлөсөн эсвэл эдгээрээс өөр бодит сонголт байхгүйгээс бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа удирдлага нь тасралтгүй байх зарчмын дагуу Компанийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах чадварыг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэгтэй. Засаглал хариуцсан этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэгтэй.

АОУС–ын дагуу хийх аудитын үед бид мэргэжлийн үнэлэмж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримтлан ажилладаг. Бид мөн:



ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ)

- Залилан эсвэл алдааны улмаас үүсч болох санхүүгийн тайлангийн материаллаг буруу тайлагналуудын эрсдэлүүдийг таних, үнэлэх, тэдгээр эрсдэлд тохирох аудитын горимуудыг боловсруулах, гүйцэтгэх, өөрсдийн дүгнэлтэд үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авах.
- Залилан нь хуйвалдах, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу мэдэгдэл хийх, дотоод хяналтыг зөрчих зэрэг үйлдлүүдтэй холбоотой байж болох тул залилангаас үүдэн гарсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүдэн гарсан буруу тайлагналыг ирүүлэхгүй байх эрсдэлээс өндөр байдаг.
- Компанийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд дүгнэлт өгөх зорилгоор биш тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитад хамааралтай дотоод хяналтын талаар ойлголт олж авах.
- Хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь зохистой эсэх, удирдлагын зүгээс нягтлан бодох бүртгэлийн ойролцоолсон тооцооллууд, тэдгээрт холбогдох тодруулгууд нь үндэслэлтэй эсэхийг үнэлэх.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын нотолгоонд үндэслэн Компанийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэж болох үйл явдал эсвэл нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг дүгнэх. Хэрэв материаллаг тодорхой бус байдал байна гэж дүгнэвэл, бид аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгыг хийж өгөх эсвэл ийм тодруулга хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэл олж авсан аудитын нотолгоонд үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөл байдал Компанийн тасралтгүй байх зарчмыг алдагдуулж болно.
- Санхүүгийн тайлангуудын (үүнд тодруулгууд багтана) ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлэх мөн санхүүгийн тайлангууд нь зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар холбогдох ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг үнэлэх.

Бид аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа, томоохон хэмжээний дутагдал болон аудитын явцад олж тогтоосон дотоод хяналтын томоохон доголдол зэргийг багтаасан асуудлуудыг Компанийн удирдлагад мэдэгддэг.

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Мянган төгрөгөөр	Тод	2023.12.31	2022.12.31
Хөрөнгө			
Эргэлтийн хөрөнгө			
Бусад авлага	8	7,346	18,681
